

БАТЛАВ.

БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин,
байгалийн нөөцийн удирдлагын газрын дарга

/Ц.Уранчимэг /

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

“Цалуут импекс” ХХК-ийн Захирал

/Д.Оюунтуяа/

**Улаанбаатар хотын Налайх дүүрэгт орших “Мал нядлан
ангилан савлах, хөлдөөж хадгалах, экспортын үйлдвэр”-ийн
2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн
ТӨЛӨВЛӨГӨӨ**

Аж ахуйн нэгжийн регистрийн дугаар: 6382398

Боловсруулсан:

“Цалуут” ХХК-ийн байгаль орчны мэргэжилтэн

/А.Отгонбаатар/

Улаанбаатар хот

2023 он

ОРШИЛ

Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний эрх бүхий “Евро Азиа Эко” ХХК-аар Улаанбаатар хотын Налайх дүүрэгт “Цалуут импекс” ХХК-ийн “Мал нядлан ангилан савлах, хөлдөөж хадгалах, экспортын үйлдвэр” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийж гүйцэтгүүлсэн ба мэргэжил арга зүйн зөвлөгөө авсны үндсэн дээр 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажлыг хийж гүйцэтгэлээ.

Энэхүү ажлыг гүйцэтгэхдээ “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай”, “Усны тухай” хуулиуд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” болон Байгаль орчин, аялал жуулчлалын яамны шинжээчийн гаргасан ерөнхий үнэлгээний дүгнэлт, нарийвчилсан үнэлгээ зэргийг үндэс болгов.

Төслийн гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг тодорхойлох, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардлыг төлөвлөх, үйлдвэрийн бүх шат дамжлага бүрд нөлөөлөл бууруулах зөвлөмж боловсруулах, үйл ажиллагааны явцад мөрдөж ажиллах байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр боловсруулах зэрэг нь зайлшгүй шаардлагатай юм.

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА БОЛОН ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЭЛ

1.1 Төслийн ерөнхий мэдээлэл:

Төслийн нэр: “Мал нядлан ангилан савлах, хөлдөөж хадгалах, экспортын үйлдвэр” төсөл.

Төслийн зорилго: Уламжлалт мал аж ахуйн гаралтай малын мах, дайвар бүтээгдэхүүнээр хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэн олон нийтэд хүргэх юм.

Төсөл хэрэгжүүлэх аж ахуйн нэгжийн нэр:

“Цалуут импекс” ХХК, регистрийн дугаар 6383398, улсын бүртгэлийн дугаар 9011779051.

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:

Улаанбаатар, Налайх дүүрэг, 5-р хороо, Нисэх хотхон 12608, 42 тоот, Утас/Факс: 976-99090862.

Төслийн байршил, хэрэгжих орчны тойм зураг:

Төсөл хэрэгжиж буй газар нь Улаанбаатар хотын Налайх дүүргийн 5-р хороонд байрладаг. Үйлдвэрийн барилгын байршил нь “Ариун цэврийн тухай хууль”, “Хүнсний тухай хууль”, “Махны хяналтын дүрэм”, MNS 5023 “Мах, махан бүтээгдэхүүн, эрүүл ахуйн аюулгүй байдлын үндсэн шаардлага” стандартад нийцсэн хүнсний үйлдвэрлэл явуулахад тохиромжтой, салхины чиглэл таарсан, намаггүй газар байршилтай.



Зураг 1. Төслийн талбайн байршил

Төслийн хүчин чадал, уурхайн ашиглалтын технологи:

Үйлдвэрийн хүчин чадал

Нийт 70 гаруй ажилтан, ажиллагсадтай үйл ажиллагаа эрхэлдэг. Нийт ажилтан, албан хаагчдын 80% нь мэргэжлийн ажиллагсад бөгөөд нийт 60 гаруй нэр төрлийн мах махан бүтээгдэхүүн болон хиам үйлдвэрлэж хэрэглэгчиддээ хүргэдэг.

“Цалуут импекс”ХХК –ний үйлдвэр жилд 800 гаруй тонн махан бүтээгдэхүүн, сард 66 тонн, өдөрт 3 тонн бүтээгдэхүүн үйлдвэрлэж зах зээлд нийлүүлдэг. Нийт махан бүтээгдэхүүний зах зээлийн 20 орчим хувийг эзэлдэг. Үйлдвэр дараах үндсэн цех, хэсгүүдээс бүрдэнэ. (Үйлдвэрийн үндсэн хүчин чадал хоногт 5 тонн) Үүнд:

- Шуллагааны өрөө
- Бэлтгэх өрөө
- Найрлагын өрөө
- Савлагааны өрөө
- Шарлагын өрөө
- Вакуум савлагааны өрөө
- Ариутгалын өрөө
- Лабораторийн өрөө

Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэр нь давхар утлагат хиам, хагас утлагат хиам, чанамал хиам, зайдас, дотор махан бүтээгдэхүүн, дулааны аргаар боловсруулсан мах, амталж хатаасан мах, хагас бэлэн бүтээгдэхүүнүүд зэрэг 53 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Тус эцсийн бүтээгдэхүүнийг өөрийн хашаанд байрлах хадгалах агуулахад түр хадгалж түгээлтэнд гаргана. Тус агуулах нь зориулалтын хөргөх төхөөрөмжтэй ба түүхий эдийг мөн энэ агуулахад хадгална.

Үйлдвэрийн барилга байгууламж

“Цалуут импекс”ХХК-ийн Мах боловсруулах үйлдвэр нь нийт 3860 м² талбайг хамрах бөгөөд үйлдвэрийн хашаанд үйлдвэр болон оффисийн 2 давхар барилга, механикийн цех, машины граж, авто машины зогсоол, ногоон байгууламжтай.



Зураг 2. Үйлдвэрийн байрны гаднах байдал



Зураг 3. Гүн хөлдөөгч буюу дотор хэсгээс



Зураг 4. Үйлдвэрийн амьд малын хашаа

Зураг 5. Мал нядлах хэсэг

Түүхий эд бэлтгэл, хангамж

Манай компани нь мал, махаа өөрсдийн олон жилийн турш харилцан ирсэн бэлтгэн нийлүүлэгч түншүүддээ тулгуурлан байнгын төлөөлөгч ажиллуулан бэлдсэн малыг Улаанбаатар хот руу машинаар болон тууварлан ирж компанийн үйлдвэрт тушаан төвлөрүүлж ирсэн. Энэ нь ченж буюу дамлан худалдаалагчдаас хамааралгүйгээр үйл ажиллагаагаа явуулах боломжийг бүрдүүлж байгаа юм.

Бид 2008 оноос хойш Хөвсгөл аймагт 1, Архангай аймагт 1, Баянхонгор аймагт 1, ГовьАлтай аймагт Буян-Ундрал хоршоо, Өвөрхангай аймагт 1, Төв аймагт 1, Сүхбаатар аймагт 1, Хэнтий аймагт 2, Дорнод аймагт 1 нийт 12 байнгын бэлтгэн нийлүүлэгчтэй болж удаан хугацааны турш хамтарч ажиллаж байна. Эдгээр бэлтгэн нийлүүлэгчид нь эхэндээ гол төлөв намар 10-12-р сарын хооронд хөдөө орон нутагтаа малаа нядалж гулууз болгон бэлтгээд түүнийгээ Улаанбаатар хот руу хүргүүлж байсан. Бусад саруудад махны нийлүүлэлт зогсонги байдалд байдаг байсан бол 2011 онд Нядалгааны үйлдвэр ашиглалтад орсноор бид Эмээлтэд ирж буй амьд малыг хүлээн авч үйлдвэртээ нядалдаг болсноор хавар 4-р сараас эхлэн өвөл 12-р сар дуустал амьд мал хүлээн авах боломжтой болж үйлдвэрээс шинэ мах

гарах нь худалдан авагчдын шаардлагад нийцэх болж үүнийгээ дагаад бусад дайвар бүтээгдэхүүнийг боловсруулах боломжтой болсон. Бид захиалагчдынхаа эрэлт хэрэгцээнд тулгуурлан өөрсдийн түншүүдээрээ дамжуулан хөдөө орон нутгаас малыг амьдаар нь хүлээн авч байгаа. Тэдний шаардлага нь үйлдвэрийн аргаар бэлтгэсэн малын махыг түлхүү сонирхдог учир гол төлөв амьд мал хүлээн авч байна. Одоогоор манай үйлдвэр нь Эмээлтэд оршдог учир Улаанбаатар хотын баруун талд ирж буй амьд малыг үйлдвэртээ шууд хүлээж авч байна. Голцуу үүнд малчид болон хувь хүмүүс ихээр хүргэж ирдэг. Мөн манай компани нь 2011 оноос хойш Говь-Алтай аймгийн Дарив сумын малчдын үүсгэн байгуулсан Б.Авирмэд даргатай “Буян-Ундрал” хоршоотой хамтарч ажиллах болсон.

"Буян-Ундрал" хоршоо 200 гаруй өрх, 300 гаруй гишүүнтэй. Түүхий эд бэлтгэн нийлүүлж борлуулах, дэлгүүр ажиллуулах, гишүүдэд хадгаламж, зээлийн үйлчилгээ үзүүлэх гэсэн гурван чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг. Хоршоо нь өөрийн мал гэж байхгүй, хоршооны гишүүд нь хувийн мал бүхий малчид юм. Тэд манай үйлдвэрт жил бүр мал махаа тушааж ирсэн. “Ногоон Алт” төсөл хэрэгжиж эхэлснээс хойш “Буян-Ундрал” хоршоотой хамтарч ажиллах болсон нь бидэнтэй хамтрах эхлэл болсон.

Ногоон алт төслийн бүрэлдэхүүн хэсэгтэй хамтарч ажиллаж байгаагийн үр дүнд:

1. Хоршоод өөрсдийн малын эрүүл ахуйд анхаарч малаа эрүүлжүүлж вакцинд тогтмол хамрагдаж гарц үр шимийг нэмэгдүүлэх болсон.
2. Хэрэглэгчдийн гарт чанартай, эрүүл, үйлдвэрийн аргаар бэлтгэгдсэн, гарал үүсэл нь тодорхой “Дээд зэрэглэлийн мах” нийлүүлэх болсон.

2018 оны дотоод зах зээл дээрх нэрийн дэлгүүрүүдийн борлуулалтыг хувьчилвал:

Манай компани нь Цалуут импекс ХХК-иар үйл ажиллагаагаа явуулж байх хугацаандаа 67 нэр төрлийн бүтээгдэхүүн борлуулалтад гаргаж байсан бөгөөд эдгээр нэр төрөл энэхүү төслийн хугацаанд мөн ижил ба зарим нь доор дурдагдсан.

Мөн “Дижитал Медик” ХХК-ний малын гарал үүслийн бичгийн систем нэвтрүүлэлтэнд зарцуулна. Одоогоор бид Налайх дүүргийн шинэ үйлдвэрийн барилгын ажилд нийт 386,000 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж газар аван, хашаа барьж, худаг гарган, цахилгаанд холбож, барилгын зураг төсөв хийлгэж зургын дагуу суурийг цутгаад байна. Бид энэ онд БНХАУ руу мах, махан бүтээгдэхүүн импортлох эрхтэй болж байгаа бөгөөд одоогийн БНХАУ-н худалдан авагчид мах махан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийн хэмжээгээр худалдан авах боломжтой байгаагаас гадна БНХАУ-н /үхэр,

адуу/ бусад компани болон Азарбайджан /хонь/ болон Вьетнам /ямаа/ улсууд руу эхний ээлжинд бүтээгдэхүүн гаргах анхдагч боломж бүрдээд байна.

100кг дайвар бүтээгдэхүүн дотроос дараах иж бүрдэл бүхий давхар дайвар бүтээгдэхүүнүүд гарахаар байна. Үүнд:

о Дотор махан таташ -65кг

о Өөх 15кг буюу 9.75кг өөхөн тос

№	Үндсэн бүтээгдэхүүний нэр	№	Дйавар бүтээгдэхүүний нэр
1	Хонины гулууз	21	Адууны умс иж бүрдэл
2	Хонины хавирга	22	Кита
3	Хонины цул мах	23	Бууз
4	Ямааны гулууз	24	Банш
5	Ямааны цул мах	25	Бөөрөнхий мах
6	Үхрийн нойтон мах	26	Гуляшны мах
7	Үхрийн цул мах	27	Хонины гэдэс иж бүрдэл
8	Үхрийн машиндсан мах	28	Таван цулын гэдэс
9	Адууны нойтон мах	29	Толгой
10	Адууны цул мах	30	Гүзээ
11	Адууны хөрөөдсөн мах	31	Зумалсан мах /бог/
12	Адууны зүрх	32	Хонины гол мах
13	Дотор махан таташ	33	Чөмөгний яс
14	Дотор махан бууз	34	Сархинаг
15	Үхрийн гол мах	35	Элгэн зайдас
16	Үхрийн ястай мах	36	Шөлний яс
17	Үхрийн хэл	37	Толгойн махан таташ
18	Үхрийн тойг	38	Өрцний мах
19	Үхрийн элэг	39	Толгой
20	Үхрийн махан таташ		

2. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ, ТҮҮНИЙ ҮНЭЛГЭЭ

2.1 Төслийн газарзүйн байрлал

Нийслэл хот нь Төв Азийн хуурай хээрийн бүсэд багтах эх газрын эрс тэс уур амьсгалтай, эргэн тойрон уулсаар хүрээлэгдсэн, голын хөндийд байрладаг.

Улаанбаатар хот нь Хэнтийн нурууны баруун өмнөд хэсэг, уулын ойт хээрийн болон хуурай хээрийн завсрын бүсд, туул голын хөндийн хойд хэсэгт Чингэлтэй (1949.7 метр д.т.д) урд талдаа Богд, баруун талдаа Сонгино хайрхан (1652.3 метр д.т.д), зүүн талдаа Налайх (1845,5 метр д.т.д) уулсаар хүрээлэгдэн зүүнээс баруун тийш сунаж тогтсон хэлбэртэй байрлана. Газрын үнэмлэхүй өндөр далайн түвшнөөс дээш 1300-1400 метрийн хооронд зонхилон байрлах бөгөөд хамгийн нам газар нь Туул голын эрэг сонгино орчим 1200 метр орчим байхад хамгийн өндөр цэг Богд уулын Цэцээ гүн оргил далайн түвшингөөс дээш 2256,3 метр байна.

2.2 Уур амьсгалын үндсэн үзүүлэлтүүд

Уур амьсгал нь Монгол орны бусад нутгийн нэгэн адил эх газрын эрс тэс шинжтэй. Энд өвөл нь хүйтэн бөгөөд удаан үргэлжилнэ. Зун нь богино. Хавар, намрын улиралд цаг агаар тогтворгүй эрс өөрчлөгдөж байдаг.

Сибирийн сөрөг циклоны нөлөөнд орших тул эх газрын эрс тэс, ширүүн уур амьсгалтай өвөл тэсгим хүйтэн, зун халуун, агаарын хоног, сар, улирлын температурын хэлбэлзэл ихтэй, агаарын жилийн температур хасах утгатай, хур тунадас бага, цасан бүрхүүл ялимгүй бага, чийг ямагт дутмаг, өвөлдөө салхигүй тогтуун, хавартаа салхи ихтэй, нарны гийгүүлэлтийн үргэлжлэх хугацаа урт байх онцлогтой.

2.3 Төсөл хэрэгжих орчны гадаргын болон гүний усны төлөв байдал

Тус судалгааны талбай нь Туул голын сав газрын дээд хэсэгт оршино. Туул гол нь Хан Хэнтий нурууны салбар уулс болох д.т.д 2000 м өндөрт өргөгдсөн Чисаалайн сарьдаг, Шороотын давааны өврөөс гарах Намъяа, Нэргүй хэмээх хоёр голын уулзвараас эх авна. Туул голын жилийн дундаж өнгөрөлт Улаанбаатар орчим 26.6, Сонгинод 25.8, Өндөрширээтэд 24.1 шоо м/с байна. Голын ус хурах талбай 48909.2 ам км, урт нь 898 км юм. Ус хагалбарын шугамын урт 2055.6 км, түүний дундаж өндөр 1719.0 м, голуудын нийлбэр урт 11046.5 км, усан сүлжээний нягтшил 0.23 км/км², ус хурах талбайн дундаж өндөр 1300.0 м, хөндийн гүн дунджаар 559.0 м, түүний өргөн 54.4 км. Туул голын өргөн нь жирийн үед 35-75 м, гүн нь 0.8-3.5 м, урсгалын хурд 0.50-1.50 м/с болно.

Туул голын ус хурах савын хэмжээнд 44013 ам км талбайд жилд 810 сая шоо метр газрын доорхи усны нөөц баялагтай байж болох тооцоо байдаг. Ай савын хэмжээнд тархсан хурдас чулуулгийн нас, литилогийн төрлийг нэлээд ерөнхийлөн нэгтгэр, тэдгээрийг нүх сүвшилт зонхилсон, эсвэл ан цавшилт зонхилсон байдлаар ангилж, газрын доорхи усны судлагдсан түвшин, хөдөлгөөны төрх зэрэг практикийн болон онолын шинжтэй хүчин зүйлсийг харгалзан уг ай савын хэмжээнд ус агуулагч нүх сүвэрхэг 10 бүрдэл, ус агуулагч ан цавлаг 5 бүсийг ялгаж, газрын доорхи усны 1 ам километр байж болох нөөц баялагаар нь 1) 50 л/с ээс дээш буюу их нөөц баялагтай, 2) 5-50 л/с буюу дунджаас их нөөцтэй, 3) 0,1-5 л/с буюу дундаж, 4) 0.1-0.3 л/с буюу дундаж хүртэл, 5) 0,03-0,3 л/с буюу бага, 6) 0,033-0,03 л/с буюу тун бага, 7) 0,003 л/с буюу үндсэндээ усгүй гэсэн долоон төрөлд хуваадаг.

2.4 Төсөл хэрэгжих орчны хөрсөн бүрхэвч

“Цалуут импекс” ХХК-ийн үйлдвэр нь Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутаг дэвсгэрт оршдог. Улаанбаатар хот нь хөрсний газарзүйн мужлалтаар хөрс-биуур амьсгалын Хангайн их мужийн Хэнтийн өмнөх тойрогт багтах бөгөөд Туул голын өргөн хөндий, Хэнтийн нурууны салбар уулын энгэр хажуугаар ихэвчлэн хар шороон, хүрэн шороон хөрс зонхилно. Улаанбаатар хотын нутаг дэвсгэр нь хөрс-газарзүйн мужлалтаар, хөрсний өндрийн бүсшилийн субгумид хэв шинж бүхий Хэнтий орчмын 52, 43-р тойргуудад хамаарагдана. Хөрсний ялзмагийн агууламж хэв шинжээс хамааран харилцан адилгүй бол урвалын орчин сул хүчиллэг, нийт хөрс тодорхой хэмжээгээр карбонат агуулсан, 10-20% хүртэл чулуурхаг, элсэнцэр хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй элс, тоосон фракц зонхилж шаврын эзлэх хувь бага.

2.5 Төсөл хэрэгжих орчны ургамлан нөмрөг

Монголын нэрт ургамал судлаач, академич Н.Өлзийхутаг “Монгол орны ургамлын аймгийн тойм” (1982) бүтээлдээ тус нутгийг Монгол орны ургамал газарзүйн мужлалаар Монгол Дагуурийн хээрийн тойрогт хамруулан авч үзсэн байдаг. (Өлзийхутаг,1982).

Богдхан уул 70 овогт хамаарах 256 төрлийн 588 зүйл дээд ургамалтай. Эдгээрийн 571 зүйл ургамал далд үртэн юм. Улалж, шарилж ортууз зэрэг 11 томоохон төрөлд хамаарах 135 зүйл ургамал нийт зүйлийн 22,9 хувийг эзэлнэ. Ургамлын аймаг экологийн 18 бүлэгт хамаарах бөгөөд эдгээрээс уулын тайгын экологийн бүлэг 80 хувь, ойт хээрийн ургамал 72 хувийг тус тус эзэлдэг. Амьдралын хэлбэрийн хувьд 87 хувийг өвслөг ургамал, 12 хувийг модлог ургамал эзэлдэг байна.

Цармын ой хээрийн болон нугын хэв шинжид хамаарах ургамлан нөмрөгтэй бөгөөд нийт талбай нь 55,8% буюу 22,9 мянган га газрыг ой мод эзэлнэ. Үүнээс шинэс 56,8%, хуш 22,2%, гацуур 15,4%, нарс 1,4%, хус 2,6%, бут сөөг 1 хувийг тус тус эзэлнэ.

Уулын оройн хярын асга, хадны завсар зайгаар бушилз, улалж, боролж зонхилсон цармын бүслүүр илэрнэ. Шинэс, хуш, ой үүсгэгч гол мод бөгөөд гацуур, нарс, хус, улиангар ургадаг. Энд тохиолдох гацууран ой монгол орны ховорхон бүлгэмдэлд тооцогдоно.

Хээрийн ургамалжил нь байрлал, зүг зовхисын ялгаа, өндрийн түвшнээс хамааран дэд хэв шинжийн түвшинд босоо бүсчлэл үүсгэнэ.

2.6 Төсөл хэрэгжих орчны амьтны аймаг

Төсөл хэрэгжих талбайн орчимд үзэгдэх амьтад:

Шувуу- Оронгийн (*P.domesticus*) ба хээрийн (*P.montanus*)бор шувуу, хөхвөр тагтаа (*C.livia*),сохор элээ (*Milvus migrans*),шаазгай (*Pica pica*),улаан хошуут (*Pyrrhocorax pyrrhocorax*),хар хэрээ (*Corvus corone*), хон хэрээ (*Corvus corax*)

Хөхтөн- гэрийн хулгана

Шавьж- хатуу далавчтан буюу цохын баг (*Coleoptera*), жийгээ цохын овгийн (*Carabidae*)- *Taphoxenus laticollis*, *Amara fodinoe*, *Harpalus amplicollis*, арьс идэгч цохын овгийн (*Dermestidae*) *Dermestes dimidiatus*, няслуур цохын овгийн (*Elateridae*)- *Selatosomus latis*, мөлгөр цохын овгийн (*Buprestidae*)- *Sphenoptera canaeiculata*, буглаа цохын овгийн *Epicauta megacephala* *Epicauta sibirica*, хайрсан далавчтаны багийн (*Lepidoptera*), дэнгийн эрвээхэйн овгийн (*Pyralidae*) *Prorophora albidogilvella*, шоргоолжийн багийн (*Forimidae*)- *Tetramorium caespitum*, сирфид, ялааны овгийн (*Syrphidae*)- *Paragus haemorrhous*, махны ялааны овгийн (*Sarcophagidae*)- *Blaesoxiphella brevicornis*, *Servaisia subamericana*, *Servaisia panfilovi*

2.7 Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн тусгай хамгаалалттай газар нутаг

Тусгай хамгаалалттай газар нутаг нь дэлхий нийтийн хэмжээнд байгаль орчны доройтлыг хязгаарлан зогсоох, байгаль экологийн тэнцвэрт байдлыг хангаж улмаар улс орнууд байгаль орчиндоо зохицон, тогтвортой хөгжих үзэл санааг баталгаажуулах, нэг үндсэн нөхцөл шалгарсан арга юм.

Төсөл хэрэгжиж буй Улаанбаатар хот нь Дархан заацат Богдхан уулын ар хормойгоор оршдог. Богдхан уул нь 1778 онд Богд хаант Монгол Улсын үед дархлагдаж байсан, дэлхийн хамгийн анхны Дархан цаазат газар юм. Богдхан уулыг УИХ-ын 1995 оны 26 дугаар тогтоолоор Богдхан уулын дархан цаазат газар хэмээн

нэрлэж, 1996 оны 05 дугаар сард ЮНЕСКО-оос Дэлхийн шим мандлын сүлжээнд оруулах шийдвэр гарч, 1997 онд гэрчилгээг олгож байв.

Богдхан уулын дархан цаазат газар /цаашид ДЦГ гэж товчилно/ нь хойд талаараа нийслэл Улаанбаатар хотын Хан-Уул, Налайх дүүрэг, урд талаараа Төв аймгийн Зуунмод, Сэргэлэн сумтай хил залгадаг, нийт 41.6 мян.га талбайтай, үүнээс онгон бүс газар нутгийн 17.3% буюу 7115.3 га, хамгаалалтын бүс нь 54.2 % буюу 22291.9 га, хязгаарлалтын бүс 28.5 % буюу 11721.8 га тус тус эзэлдэг.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

“Мал нядлан ангилан савлах, хөлдөөж хадгалах, экспортын үйлдвэр” төслөөс байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл нь:

1. Хатуу хог хаядлыг цуглуулах, зайлуулах журам, дэглэм, зөвлөмжийг баримтлаагүй тохиолдолд хөрс, ус болон агаар орчныг бохирдуулах.
2. Машин, техникийн завсар үйлчилгээг зориулалтын бус газар хийснээр хөрс, гүний усыг бохирдуулах.
3. Хөдөлмөрийн аюулгүй байдал алдагдах, гал түймэр гарах зэрэг нь тухайн орчинд үйл ажиллагаа явуулж буй бусад аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж, хүний эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгө, материалын хохирол учрах магадлалтай.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2023 ОНЫ ГОЛ ЗОРИЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, үйл ажиллагааг зүй зохистой явуулах, БОННҮнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Төсөл хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээд нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлж байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.

Төслийн үйлдвэрлэлийн бүх үе шатны үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчны бүрэлдэхүүн хэсэг болох ус, ургамал, агаар, амьтан, хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, нөлөөллийн бүсэд орших айл өрх, үйлдвэрт ажиллаж буй

ажилчдад ээлтэй үйл ажиллагаа явуулах зорилгоор 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжилтийг ханган ажиллах зорилготой.

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Үйлдвэрийн агааржуулалт хөргөлтийн системээс ялгарах хий агаарт сул дэгдсэнээр агаарын чанарт нөлөөлөх	Үйлдвэрийн агааржуулалт, хөргөлтийн системд хяналт тавих засвар үйлчилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Үйлдэр, оффисын байр		100,000.0	2	200,000.0	Жилд 2 удаа	Монрелийн протоколтой нийцүүлэх
2	Ахуйн болон үйлдвэрийн хатуу хог хаягдал, барилга байгууламжаас гарах хог хаягдлаас үүдэн хөрс орчин бохирдох	Үйлдвэрийн хог хаягдал түр хадгалах цэгийг сайжруулах, хаягдлыг ангилаан ялгаж тэмдэгжүүлэх	Үйлдэр, оффисын байр		50,000.0		50,000.0	Жилд 1 удаа	Хог хаягдлын тухай хууль
3	Машины граш, засварын газарт тос маслоор хөрс бохирдох	Машины граш, зогсоолд тос масло асгарсан тохиолдолд цэвэрлэх багаж хэрэгсэл саармагжуулах бодис бүхий цэг байгуулах	Үйлдэр, оффисын граш, авто зогсоол		60,000.0		60,000.0	Жилд 1 удаа	Үйлдвэрийн ХАБ-ын дүрэм
4	Үйлдвэрийн нөлөөгөөр хортон шавьж ихсэх, ойр орчмын ногоон байгууламж устах	Ногоон байгууламжийн тохижилтод анхаарах, шавь ихэссэн тохиолдолд мэргэжлийн байгууллагаар ариутгал хийлгэх	Үйлдэрмйн гадна талбай		150,000.0		150,000.0	Жилд 2 удаа	

Налайх дүүргийн 5-р хорооны нутагт орших “Мал нядлан ангилан савлах, хөлдөөж хадгалах, экспортын үйлдвэр” төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

5	Үйлдвэрт болон ахуйн хэрэглээний усны ашгалт ихсэх шаардлаггүй хэрэглээ үүсч усны алдагдал үүсэх.	Усны зүй зохистой хэрэглээний талаар ажилчдад сургалт мэдээлэл орох, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах.	Үйлдвэр, оффисын бүх ажилчид		100,000.0		100,000.0	Жилд 1 удаа	Усны тухай хууль
	Нийт						560,000.0		

6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Орчны ая тухтай байдлыг нэмэгдүүлэх	Ногоон байгууламжийг цэвэрлэх, хэлбэржүүлэх	Үйлдвэр, оффисын ногоон байгууламж	-	2	50,000.0	100,000.0	Жилд 2 удаа	
2	Ногоон байгууламж дахь ургамлын зүйлийн тоог нэмэгдүүлэх	Ногоон байгууламжид байхгүй зүйл сортийн ургамал суулгах	Үйлдвэр, оффисын ногоон байгууламж	-	15	10,000.0	150,000.0	Жилд нэг удаа	
	Нийт						250,000.0		

7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбай, үйл ажиллагаанд өртөх түүх, соёлын өв төслийн талбай, үйлдвэрийн байрны ойр орчимд байхгүй.

8. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэжмээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Үйлдвэрийн байрны гал түймрийн аюул	Гал унтраах анхан шатны болон суурин тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах, тоног төхөөрөмжийг ашиглах чадамж эзэмших, ХАБ-ын сургалт явуулах	Үйлдвэр, оффисын байр	1	300,000.0	300,000.0	Жилд 1 удаа	Монгол улсын “Галын байдлын тухай хууль”, “Аж ахуйн нэгж байгууллагад дагаж мөрдөх галын аюулгүйн дүрэм”-
	Нийт					300,000.0		

9. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Ахуйн	Хог хаягдлын ангилан ялгалтын 2, 3 төрлийн савнууд байршуулах.	Үйлдвэр, оффис	-	30,000.0	1	200,000.0	Үйл ажиллагааны туршид	Хог хаягдлын тухай хууль
2	Үйлдвэрийн	Шингэн хаягдалд байнгын хяналт тавих, үйлдвэрээс гарах шингэн хяагдлыг шүүн өөх тосыг хаман авах	Үйлдвэр	-	120,000.0	1	120,000.0	Үйл ажиллагааны туршид	Хог хаягдлын тухай хууль
3	Аюултай	Лабораториос гарах хог хаягдлыг ангилан, тэмдэгжүүлэх, тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар зөөлгөх.	Лаборатори	-	250,000.0		250,000.0	Үйл ажиллагааны туршид	Аюултай хог хаягдлын тухай хууль
	Нийт						570,000.0		

10. Тэрбум мод хөтөлбөр

Сонгосон талбай	Талиалалт хийх талбай	Тоохэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
Үйлдвэрийн байрны урд хэсэгт	2м X 25м 50 м ² талбай	Нийт 50ш суулгац	4,500.0 төгрөг	225.0 мян.төг	4-р улиралд

11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
1	Хөрсний механик бүрэлдэхүүн	Үйлдвэрийн ногоон байгууламж	жилд 1 удаа	1	30,000.0	40,000.0	Итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэх	MNS 5820:2008
2	Хөрсний аграхимийн найрлага	Үйлдвэрийн ногоон байгууламж	жилд 1 удаа	1	30,000.0	40,000.0		MNS 5820:2008
3	Хөрсөн дэх пестицид, гербицидийн үлдэгдэл	Үйлдвэрийн ногоон байгууламж	жилд 1 удаа	1	40,000.0	80,000.0		MNS 5820:2008
	Нийт					160,000.0		

12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцоолсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан
			2023 он			
			8 сар	9 сар	10сар	
1	Үйлдвэрийн агааржуулалт, хөргөлтийн системд хяналт тавих засвар үйлчилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	200,000.0	+			Үйлдвэрийн дарга
2	Үйлдвэрийн хог хаягдал түр хадгалах цэгийг сайжруулах, хаягдлыг ангилаан ялгаж тэмдэгжүүлэх	50,000.0	+			Үйлдвэрийн дарга
3	Машины зогсоолд тос масло асгарсан тохиолдолд цэвэрлэх багаж хэрэгсэл саармагжуулах бодис бүхий цэг байгуулах	260,000.0	+			Үйлдвэрийн дарга

Налайх дүүргийн 5-р хорооны нутагт орших “Мал нядлан ангилан савлах, хөлдөөж хадгалах, экспортын үйлдвэр” төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

4	Ногоон байгууламжийн тохижилтод анхаарах, шавь ихэссэн тохиолдолд мэрэгжлийн байгууллагаар ариутгал хийлгэх	350,000.0		+		ХАБ-ын ажилтан
5	Усны зүй зохистой хэрэглээний талаар ажилчдад сургалт мэдээлэл орох, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах.	1,000,000.0	+			ХАБ-ын ажилтан
6	Ногоон байгууламжийг цэвэрлэх, хэлбэржүүлэх	500,000.0		+		Үйлдвэрийн дарга
7	Ногоон байгуулмажд байхгүй зүйл сортийн ургамал суулгах	150,000.0		+		Үйлдвэрийн дарга
8	Гал унтраах анхан шатны болон суурин тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах, тоног төхөөрөмжийг ашиглах чадамж эзэмших, ХАБ-ын сургалт явуулах	100,000.0	+			ХАБ-ын ажилтан
9	Хог хаягдлын ангилан ялгалтын 2, 3 төрлийн савнууд байршуулах.	200,000.0	+			Үйлдвэрийн дарга
10	Шингэн хаягдалд байнгын хяналт тавих, үйлдвэрээс гарах шингэн хяагдлыг шүүн өөх тосыг хаман авах	120,000.0	+	+	+	Үйлдвэрийн дарга
11	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	160,000.0			+	Үйлдвэрийн дарга
	Нийт	3,090,000.0				

13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацаа тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан	Зохион байгуулах газар
---	---	------------------	--------------------	------------------------------	-----------------------	---	------------------------

Налайх дүүргийн 5-р хорооны нутагт орших “Мал нядлан ангилан савлах, хөлдөөж хадгалах, экспортын үйлдвэр” төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

1	Төсөл хэрэгжүүлэгч	Уулзалт	2023 оны БОМТ-ний хэрэгжилт	2023 оны 12 сар	40,000.0	Үйлдвэрийн дарга	Хорооны иргэний танхим
2	Нийслэлийн байгаль орчны газар	Уулзалт	2023 оны БОМТ-ний хэрэгжилт	2023 оны 12 сар	-	Үйлдвэрийн дарга	Үйлдвэрийн талбай

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН: “ЦАЛУУТ ИМПЕКС” ХХК